## ГАРЧИГ

**1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ ........ 4**
1.1. Товч танилцуулга ........ 4
Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр, мэдээлэл ........ 4
1.2. Төслийн зорилго ........ 4
1.3. Төслийн байршил ........ 4
1.4. Ордыг ашиглах технологийн сонгол ........ 5
1.5. Ил уурхайн олборлолт ........ 5
1.6. Усны хэрэглээ ........ 6
1.6.1. Ажилчдын унд ахуйн ус хэрэглээ ........ 6
1.6.2. Уурхайн технологийн ус хэрэглээ ........ 6
1.6.3. Зам талбайн тоосжилт дарах усны хэрэглээ ........ 6
1.6.4. Ногоон байгууламжийн усалгаа арчилгаа ........ **Error! Bookmark not defined.**
**2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт ........ 7**
2.1. Олон салаа зам гарахаас урьдчилан сэргийлж дотоод болон гадаад замын 2 талаар тэмдэг, тэмдэглэгээ хийх ........ 7
2.2. Хөрсөнд шатах тослох материал алдагдахаас сэргийлж гэмтэл, эвдрэлтэй машин техникийг ажлын талбайд гаргахгүй байх ........ 7
2.3. Уурхайн ажилчид, суурин дахь захиргаа-үйлчилгээний ажиллагсдын зорчих явган хүний зам, талбайг зориулалтын хайрган хучилттай болгох. ........ 8
2.4. Дуу чимээ бага гаргадаг, техникийн үзүүлэлт сайтай тоног төхөөрөмжүүд ашиглах. 8
2.5. Ургамлын нарийн судалгаа мэргэжлийн байгууллагаар хийлгэх ........ 9
2.6. Ахуйн бохир ус зайлуулах цэгийг стандартын дагуу байгуулах. ........ 10
2.7. Зам талбайн тоосжилтыг бууруулах, дотоод тээврийн зам, хөрсний овоолгоос үүсэх тоосжилтийг бууруулах ........ 10
2.8. Авто зогсоол, засварын газрын талбайг хатуу хучилттай зам болгох ........ 11
2.9. Ажилчдын зөөврийн ариун цэврийн байгууламж ашиглах зөвлөмж ........ 11
2.10. Ариун цэврийн байгууламж, бохир усны цооног, хог хаягдлын цэг нийт 3 цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, орчныг бохирдуулахаас сэргийлэх. ........ 11
2.11. Цахилгаан дамжуулах шугаманд шувуу үргээгч суурьлуулах. ........ 11
2.12. Гүний худагт тоолуур суурьлуулах ........ 12
**3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ........ 13**
3.1. Шимт хөрсний овоолгыг хадгалах, хамгаалах ........ 13
3.2. Нөхөн сэргээлтийн бэлтгэл ажил ........ 13
3.3. Техникийн нөхөн сэргээлт. ........ 13
3.4. Биологийн нөхөн сэргээлтийн ажил ........ 15

**4. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ ........ 15**
4.1. Тэрбум мод төлсийн хүрээнд 500ш мод тарих ........ 15
**5. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨний биелэлт ........ 17**
5.1. Амьтдын тоо толгой буурах, дайжих, амьдрах орчин устах, идэш тэжээл хомсдохоос хамгаалах ........ 17
5.2. Биологийн олон янз байдлын менежментийн арга хэмжээг тодорхойлох (Нэн ховордсон ургамлын нүүлгэн шилжүүлэх) ........ 18
**6. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний биелэлт ........ 19**
**7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт ........ 19**
**8. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт ........ 19**
**9. хог хаягдлын төлөвлөгөөний биелэлт ........ 20**
9.1. Хатуу хог хаягдлын ангилан ялгах түр цэг байгуулах ........ 20
9.2. Ахуйн хэрэглээнээс гарах хог хаягдлыг зайлуулах гэрээг айраг сумын ТҮК-тай байгуулж сумын нэгдсэн хогийн цэгт тогтмол зөөвөрлөх ........ 21
9.3. Хог түр хадгалах цэгт цугларсан хогийг тогтмол хугацаанд зөвшөөрсөн цэгт тээвэрлүүлж байх ........ 22
**10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР ........ 23**
10.1. Агаарын тоос тоосонцор (PM2.5, PM10) ........ 23
10.2. Усны хими, физикийн үзүүлэлт Микробиологийн үзүүлэлт ........ 25
10.3. Хөрсний шинжилгээ /Жилд 1 удаа/ ........ 25
10.4. Дуу чимээ ........ 29
**11. Уурхайн үйл ажиллагаа байгаль орчинд хэрхэн нөлөөлж байгаа нөлөөлөл болон сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээг хэрхэн авч хэрэгжүүлсэн, хяналт мониторингийн явцыг танилцуулах ........ 30**
11.1. Орон нутгийн Байгаль орчны газарт ........ 30
11.2. Орон нутаг олон нийтэд танилцуулах ........ 30
11.3. Бүх шатны Засаг дарга, Байгаль орчны улсын байцаагч, орон нутгийн байцаагч.. 30
11.4. Төрийн захиргааны байгуулагт танилцуулах ........ 30
**12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ЗАРДАЛ 31**

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн байршил ........ 4
Зураг 2. Тэмдэг тэмдэглэгээ ........ 7
Зураг 3. Уурхайн ШТС хатуу хучилттай болгосон байдал ........ 8
Зураг 4. Уурхайн тоног төхөөрөмж ........ 8
Зураг 5. Раменскийн 1м2-ийн хэмжээст тор ........ 9
Зураг 6. Ургамлын судалгаа хийсэн байршилын сансрын зураглал ........ 9
Зураг 7. Кольцо авсан баримт ........ 10
Зураг 8. Усалгааны машин ........ 11
Зураг 9. Ариун цэврийн байгууламжид халдваргүйжүүлэлт хийж буй ........ 11

Зураг 10. Шувуу үргээгч ..... 11
Зураг 11. Тоолуур баталгаажуулсан акт ..... 12
Зураг 12. Тоолуурын гэрчилгээ ..... 12
Зураг 13. Уурхайн зохион байгуулалт ..... 13
Зураг 14. Нөхөн сэргээлт хийсэн талбай ..... 14
Зураг 15. Нөхөн сэргээлт хийхээс өмнө ..... 14
Зураг 16. Нөхөн сэргээлт хийсний дараа ..... 15
Зураг 17. Раменскийн 1м2-ийн хэмжээст тор ..... 18
Зураг 6. Ургамлын судалгаа хийсэн байршилын сансрын зураглал ..... 18
Зураг 18. Хог хаягдлын цэг ..... 20
Зураг 19.Хог хаягдлын төлбөр төлсөн баримт ..... 20
Зураг 20. Хог хаягдлын гэрээ ..... 22
Зураг 21. CEM-DT-96 зөөврийн тоос хэмжигч багаж болон сертификат ..... 23
Зураг 22. 2024 оны 9 сарын 15ны өдрийн PM2.5 PM10 тоосонцрын хэмжилтийн үр дүн ..... 24
Зураг 23. Уурхайн карьер №1-ээс авсан хөрсний химийн шинжилгээний үр дүнг харуулсан график ..... 26
Зураг 24. Уурхайн карьер №2-оосс авсан хөрсний химийн шинжилгээний үр дүнг харуулсан график ..... 26
Зураг 25. Засварын газраас авсан хөрсний дээжийн хүнд металлын агууламжийн үр дүнг харуулсан график ..... 27
Зураг 26. Авто зогсоолоос авсан хөрсний дээжийн хүнд металлын агууламжийн үр дүнг харуулсан график ..... 27
Зураг 27. ШТС авсан хөрсний дээжийн хүнд металлын агууламжийн үр дүнг харуулсан график ..... 28
Зураг 28. Кемпээс авсан хөрсний дээжийн хүнд металлын агууламжийн үр дүнг харуулсан график ..... 28

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн талбайн солбицол ..... 5
Хүснэгт 2. Уурхайн ажиллах хоног ..... 5
Хүснэгт 3. Зам усалгааны тооцоо ..... 6
Хүснэгт 4. Зам усалгааны тооцоо ..... 6
Хүснэгт 5. Раменскийн 1м2 торнд зонхилж буй ургамал ..... 9
Хүснэгт 6. Нөхөн сэргээлт хийсэн талбайн байршил ..... 13
Хүснэгт 5. Раменскийн 1м2 торнд зонхилж буй ургамал ..... 19

# 1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

## 1.1. Товч танилцуулга

| Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нэр, мэдээлэл | • “Экилешия” ХХК<br>• РД: 5411726<br>• Улсын бүртгэлийн дугаар: 9011254020<br>• Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-014111<br>• Хаяг: Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Нарны зам, 87-305 тоот<br>• Утас: 99275568 |
|---|---|

## 1.2. Төслийн зорилго

Уурхайн үндсэн зорилго нь байгалийн баялгийг ашиглахад чиглэсэн бөгөөд нөлөөлөл нь мөн шууд, буцалтгүй шинжтэй болно. Иймд Монгол улсын Газрын хэвлийн хууль, Ашигт малтмалын хууль, Байгаль хамгаалах хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, байгалийн баялгийг алдагдал хаягдалгүй бүрэн ашиглах, байгаль орчныг нөхөн сэргээх ажлыг жил бүр үйлдвэр, санхүүгийн төлөвлөгөөндөө тусгаж хэрэгжүүлж ажилласан.

## 1.3. Төслийн байршил

Баруун Цагаан дэлийн “Жонш Толгойн” хайлуур жоншны орд нь Дорноговь аймгийн Айраг сумын нутаг дэвсгэрт оршино. Улаанбаатар хотоос зүүн урагш 320 орчим км, Дорноговь аймгийн Айраг сумаас баруун урагш 23 орчим км зайтай байрлана. Ашиглалтын MV-014111 тоот тусгай зөвшөөрөл бүхий Жоншт толгойн хайлуур жоншны ордын 1, 2, 3-р хүдрийн биетийн талбай хэмжээ 38.0 га бөгөөд дараах газар зүйн солбилцлоор хязгаарлагдана.




**Зураг 1. Төслийн талбайн байршил**

**Хүснэгт 1. Төслийн талбайн солбицол**

| № | Уртраг | | | Өргөрөг | | |
|---|---|---|---|---|---|---|
| | град | мин | сек | град | мин | сек |
| 1 | 109 | 7 | 26.72 | 45 | 40 | 26.61 |
| 2 | 109 | 7 | 26.72 | 45 | 40 | 9.61 |
| 3 | 109 | 7 | 51.72 | 45 | 40 | 9.61 |
| 4 | 109 | 7 | 51.72 | 45 | 40 | 1.62 |

### 1.4. Ордыг ашиглах технологийн сонгол

Төслийн техник эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/-д тусгаснаар ордын хайлуур жоншны судал нь 700 уналтай, зузаан нь дунджаар 3.92 м байна. Газрын гадаргатай ойрхон судалтай өмнө нь ил аргаар ашиглаж байсан учир авто тээвэртэй ил аргаар ашиглахад тохиромжтой байсан.

### 1.5. Ил уурхайн олборлолт

Ордын хайлуур жоншны судал нь 700 уналтай, зузаан нь дунджаар 3.92 м байна. Газрын гадаргатай ойрхон судалтай өмнө нь ил аргаар ашиглаж байсан учир авто тээвэртэй ил аргаар ашиглах тохиромжтой гэж үзлээ.

**Хүснэгт 2. Уурхайн ажиллах хоног**

| ТЕХНОЛОГИ | ҮНДСЭН АЖИЛ | ТЕХНОЛОГИЙН ПРОЦЕССУУД |
|---|---|---|
| Авто тээвэртэй ашиглалтын технологи | Хөрс хуулалт | Тэсэлгээ хийх |
| | | Ухаж ачих |
| | | Тээвэрлэх |
| | | Гадаад овоолго |
| | Хүдэр олборлолт | Тэсэлгээ хийх |
| | | Ухаж ачих |
| | | Тээвэрлэх |

Жоншт толгойн ордын нөөцийг аль болох бүрэн ашиглах зорилгоор захиалагч талд бэлэн байгаа тоног төхөөрөмж, уурхайн орлын өргөн болон ажлын хамгийн бага талбайгаас хамааран загварчилахад 62841 тонн хүдэр олборлон, 1947.15 тонн хүдэр хүрээ хязгаараар хязгаарлагдаж байхаар төсөлд тусган байна. Жоншт толгойн 1, 2, 3-р хүдрийн биетүүдийн хайлуур жоншны ил уурхайн хил хязгаарыг нийт В зэрэглэлийн нөөцийг ашиглах хүрээнд дараах байдлаар явуулахаар тогтоов. Уурхайн дундаж гүн 29м, урт 127м, өргөн 25м бөгөөд уурхайн талбайн хэмжээ 1.35 га байхаар төлөвлөж байна. Ил уурхайн хил хүрээг сонгохдоо ордын нөөцийг иж бүрэн ашиглах боломж, уурхайн хүчин чадал, аюулгүй ажиллагааны шаардлага, байгаль орчны нөхөн сэргээлтийн хэтийн төлөв байдал, эдийн засгийн хувьд хамгийн бага зардлаар ашиглах нөхцөл зэргүүдийг харгалзан үзлээ. Мөн II-р бүлгийн орд тул В нөөцөнд тулгуурлан нөөцийн тооцоог хийсэн байна.




### 1.6. Усны хэрэглээ

Ажилчдын унд-ахуйн усыг гүний худгаас зөөврөөр хангана. Зам талбайн усалгаа, биологийн нөхөн сэргээлтэнд ашиглах усыг уурхайд шүүрэх уснаас ашиглана.

#### 1.6.1. Ажилчдын унд ахуйн ус хэрэглээ

**Хүснэгт 3. Зам усалгааны тооцоо**

| Төсөл хэрэгжих үед | Ажилчдын тоо | Норм, л | Хоногт /л/ | Жилд /м3/ |
|---|---|---|---|---|
| | 30 | 20 л/хон | 600 | 147 |

#### 1.6.2. Уурхайн технологийн ус хэрэглээ

Тус ордын жоншны хүдрийг гар аргаар ялгаж, 75% $CaF_2$-ын агуулга бүхий баяжмал гарган авах технологийг сонгосон байна. Ил уурхайгаас нийлүүлэгдэх хүдрийг (<400 мм) хацарт бутлуураар 40 мм хүртэл бутлан, бутлагдсан хүдрийг чичиргээт шигшүүрээр шигшин шигшүүрийн доод бүтээгдэхүүнийг хаягдлын овоолгод зөөвөрлөн хураана. Шигшүүрийн дээд бүтээгдэхүүнийг гар ялгалт хийн ФК-75 маркийн бүхэллэг жонш гарган авах ба хаягдлыг овоолгод хураахаар төсөлд тусгажээ. Иймд ил уурхайн технологийн явцад ус ашиглаагүй болно.

#### 1.6.3. Зам талбайн тоосжилт дарах усны хэрэглээ

БОАЖСайдын А/301 дугаар тушаалын 13 дугаар хавсралтын дагуу Зам, талбайн тоосжилт дарах усалгааны норм 1 м2 талбайд 2 л байна. Төсөл хэрэгжих талбайн уур амьсгалын мужлалыг харгалзан замын усалгааг сард 5-10 удаа, жилд 34 удаа услахаар тооцлоо.

Зам усалгааны усыг уурхай олборлох үйл явцад гарсан шүүрлийн усаар усална.

# 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

## 2.1. Олон салаа зам гарахаас урьдчилан сэргийлж дотоод болон гадаад замын 2 талаар тэмдэг, тэмдэглэгээ хийх

Авто тээврийн хөдөлгөөнөөс үүдэн олон салаа зам гарахаас сэргийлэхийн тулд гадаад болон дотоод замын нийт 18ш тэмдэг тэмдэглэгээ уурхайн үйл ажиллагаатай уялдуулан байршуулсан.






| | | | | |
|---|---|---|---|---|
| 1 |  1.10 | 2 ш | Замын тэмдэг | Стандарт |
| 2 |  | 2 ш | Замын тэмдэг | Стандарт |
| 3 |  | 4ш | баруун зүүн салсан тус бүр 2 | стандарт |
| 4 |  5.7 | 3 ш | | стандарт |
| 5 |  | 1ш | | стандарт |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 6 |  | 2ш | Уурхай гадаа байрлуулах | стандарт |
| 7 |  | 2ш | Уурхайн дотор | стандарт |
| 8 |  | 1ш | | |
| 9 |  | 1ш | | |

**Зураг 2. Тэмдэг тэмдэглэгээ**

## 2.2. Хөрсөнд шатах тослох материал алдагдахаас сэргийлж гэмтэл, эвдрэлтэй машин техникийг ажлын талбайд гаргахгүй байх

Хөрсөнд ШТМ алдагдаж хөрс рүү нэвчилт үүсхээс сэргийлж ШТС талбайг хатуу хучилттай болгосон. Мөн машин техникийн засвар үйлчилгээг тогтмол хийж гүйцэтгэдэг ба эвдрэл гэмтэлтэй машин техникийг уулын ажилд гаргадаггүй болно.




**Зураг 3. Уурхайн ШТС хатуу хучилттай болгосон байдал**

**2.3. Уурхайн ажилчид, суурин дахь захиргаа-үйлчилгээний ажиллагсдын зорчих явган хүний зам, талбайг зориулалтын хайрган хучилттай болгох.**

Уурхайн явган хүний замын хайрган хучилтыг нэмэгдүүлсэн.

**2.4. Дуу чимээ бага гаргадаг, техникийн үзүүлэлт сайтай тоног төхөөрөмжүүд ашиглах.**

Уурхайд стандартын шаардлага хангасан 2020-2021 онд үйлдвэрлэгдсэн тоног төхөөрөмж ашигладаг болно.

**УУРХАЙН ОЛБОРЛОЛТЫН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИ**

| № | Тоног төхөөрөмжийн нэр | | | | Хүчин чадал багтаамж | | Ашиглалтын хугацаа | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Марк | Төрөл | Загвар | Үйлдвэрлэсэн улс | Нэгж | Хэмжээ | Үйлдвэрлэсэн он | Ашиглалтад өгсөн он | Ашиглал хугаца |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | KOMAT'SU | Экскoватор | PC-650 LC | БНСУ | м3 | 2.5 | 2020 | 2021 | |
| 2 | KOMAT'SU | Экскoватор | PC-300 | БНХАУ | м3 | 1.3 | 2021 | 2021 | |
| 3 | CATERPILLAR | Экскoватор | CAT-330C | БНХАУ | м3 | 1.5 | 2021 | 2021 | |
| 4 | CATERPILLAR | Экскoватор | CAT-349D | БНХАУ | м3 | 3.0 | 2021 | 2021 | |
| 5 | XCMG | Экскoватор | SDLG E6600 | | м3 | 3.2 | 2020 | 2022 | |
| 6 | XCMG | Экскoватор | SDLG E6600 | | м3 | 3.2 | 2020 | 2022 | |
| 7 | VOLVO | Экскoватор | VOLVO EC700 | | м3 | 1.5 | 2020 | 2021 | |
| 8 | KOMAT'SU | Экскoватор | PC-650 CSE | | м3 | 2.5 | 2020 | 2022 | |
| 9 | XCMG | Утгуурт ачигч | L58 | | м3 | 3.0 | 2020 | 2020 | |
| 10 | XCMG | Утгуурт ачигч | L58 | | м3 | 3.0 | 2020 | 2021 | |
| 11 | Бусад | Автосамосвал | MT-86 | | тн | 60.0 | 2020 | 2020 | |
| 12 | Бусад | Автосамосвал | MT-86 | | тн | 60.0 | 2020 | 2020 | |
| 13 | Бусад | Автосамосвал | MT-86 | | тн | 60.0 | 2020 | 2020 | |
| 14 | Бусад | Автосамосвал | MT-86 | | тн | 60.0 | 2020 | 2020 | |
| 15 | Бусад | Автосамосвал | MT-86 | | тн | 60.0 | 2020 | 2020 | |
| 16 | Бусад | Автосамосвал | MT-86 | | тн | 60.0 | 2020 | 2021 | |
| 17 | Бусад | Автосамосвал | MT-86 | | тн | 60.0 | 2020 | 2021 | |
| 18 | Бусад | Автосамосвал | MT-86 | | тн | 60.0 | 2020 | 2024 | |
| 19 | Бусад | Автосамосвал | MT-86 | | тн | 60.0 | 2020 | 2024 | |

**Зураг 4. Уурхайн тоног төхөөрөмж**

## 2.5. Ургамлын нарийн судалгаа мэргэжлийн байгууллагаар хийлгэх

Уурхайн талбайн хойд хэсэгт (45°40'17.57"N 109° 7'13.90"E) хээрийн судалгааны үр дүнг үндэслэн тодорхойлоход Монгол өвс-хазаар өвст бэлчээрийн төрөл тархсан байна. Мөн 1м2 талбайн бүрхэц 25%, ургамлын дундаж өндөр 15 см байна. 2025 онд ургамлын судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэхээр төлөвлөж байна.



**Зураг 5. Раменскийн 1м2-ийн хэмжээст тор**




**Зураг 6. Ургамлын судалгаа хийсэн байршилын сансрын зураглал**

**Хүснэгт 4. Раменскийн 1м2 торнд зонхилж буй ургамал**

| Зонхилж буй ургамал | | |
|---|---|---|
| **№** | Шинжлэх ухааны нэр | Монгол нэр |
| **1** | Stripa gobica Roshev | Говийн хялгана |
| **2** | Cleistogenes songorica | Зүүн гарын хазаар өвс |
| **3** | Allium polyrrhizum | Таана |
| **4** | Allium mongolicum | Хөмүүл |

## 2.6. Ахуйн бохир ус зайлуулах цэгийг стандартын дагуу байгуулах

Уурхайн ашигласан ахуйн бохир ус зайлуулах цэгийг байгуулахын тулд 2ш кольцо худалдан авсан ба дулааны улиралд суурилуулна.



НЭХЭМЖЛЭХ № ......

Нэхэмжлэгч: Байгууллагын нэр: Дэлгэрэх ундрах ХХК; Хаяг:; Утас, Факс: 9000 4308; Э_шуудан:; Банкны нэр: ХХБ; Банкны дансны дугаар: 421011038; Регистрийн №: 6020515

Төлөгч: 99104400; Байгууллагын нэр: Экилешия ХХК; Хаяг:; РД: 5411826; Гэрээний №:; Нэхэмжилсэн огноо: 24.10.31; Төлбөр хийх хугацаа:

| № | Гүйлгээний утга | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|
| | 1580 Кольцо | 4ш | 343,200 | 1372,800 |
| | 1500 үх | 1ш | 165,000 | 165,000 |
| | | | Дүн | |
| | | | НӨАТ | |
| | | | Нийт дүн | 1,537,800 |

Мөнгөний дүн ........ (үсгээр) ........ болно.

(Тамга) Дарга ........ / Хүлээн авсан ........ / Нягтлан бодогч ........

Зураг 7. Кольцо авсан баримт

## 2.7. Зам талбайн тоосжилтыг бууруулах, дотоод тээврийн зам, хөрсний овоолгоос үүсэх тоосжилтийг бууруулах

2024 оны уурхайн замын тоосжилт дарах

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 | 23 | 24 | 25 | 26 | 27 | 28 | 29 | 30 | 31 | Нийт өдөр | Тоосжилт /м3/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1-р сар | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | 0 | - |
| 2-р сар | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | 0 | - |
| 3-р сар | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | 0 | - |
| 4-р сар | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | 0 | - |
| 5-р сар | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | 0 | - |
| 6-р сар | | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | | 6 | 54.00 |
| 7-р сар | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | 5 | 45.00 |
| 8р сар | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | 7 | 63.00 |
| 9-р сар | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | | 6 | 54.00 |
| 10-р сар | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | a | 10 | 90.00 |
| Нийт ажиллах хоног, тоосжилт дарах усалгааны хэмжээ /м3/ | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | 34 | 306.00 |

Зураг 8. Уурхайн замын тоосжилт дарах усалгаа

Зам талбайн тоосжилтыг бууруулах зорилгоор 15тн багтаамжтай машинаар дотоод тээврийн замыг усалдаг. 2024 оны 06 сараас 10 сарын хооронд долоо хоногт 2-3 удаа зам талбайн усалгаа хийдэг. 2024 онд 4500м замыг нийт 34 удаа усалгаа хийсэн ба нийт 306 $м^3$ ус зам талбайн усалгаанд ашигласан байна.



**Зураг 9. Усалгааны машин**

**2.8. Авто зогсоол, засварын газрын талбайг хатуу хучилттай зам болгох**

Авто зогсоол болон, засварын газрыг талбайн 2025 онд кемп нүүхээр хийж гүйцэтгэнэ.

**2.9. Ажилчдын зөөврийн ариун цэврийн байгууламж ашиглах зөвлөмж**

Уурхайн ажилчдыг хувцас угаасан, нүр гар угаасан хаягдал усыг зориулалтын бохир усны цооногт хаях тухай зөвлөмж сануулгыг өгч ажилласан.

**2.10. Ариун цэврийн байгууламж, бохир усны цооног, хог хаягдлын цэг нийт 3 цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, орчныг бохирдуулахаас сэргийлэх.**

Уурхайн ариун цэврийн байгууламж, бохир усны цооног болон хог хаягдлын цэгийг хлорын уусмалаар тогтмол ариутгал халдваржүүлэлт хийдэг.



**Зураг 10. Ариун цэврийн байгууламжид халдваргүйжүүлэлт хийж буй**

**2.11. Цахилгаан дамжуулах шугаманд шувуу үргээгч суурьлуулах**

Уурхайн цахилгаан дамжуулах шугаманд 2ш шувуу үргээгч байрлуулахаар худалдан авсан байгаа боловч суурилуулалтын ажил хийгдээгүй.




**Зураг 11. Шувуу үргээгч**

## 2.12. Гүний худагт тоолуур суурьлуулах

Уурхайн шүүрлийн ус татан зайлуулах шугамд LXLC-100 загварын 100мм-ийн голчтой тоолуурыг тоолуурын баталгаажуулсан актыг Айраг сумын БО мэргэжилтэнтэй байгуулсан.



ТООЛУУР БАТАЛГААЖУУЛСАН АКТ

Компаний нэр: ЭКИЛЕШИЯ ХХК РД: 5411726

Тайлант хугацаа ......2024.........

| Сар ууд | Худаг | Тоолуурын заалт | Нийт заалт | Хэрэглээ /м³/ | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ | Төлсөн | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 06 сар | Цооног | 0000002 | | | 1184 | | | |
| Нийт | | | | | | | | |

Жич: Усны төлбөрийг Дорноговь төрийн сан банкин дахь төсвийн орлогын 100 060000944 тоот дансанд тушаах

ТООЛУУР СУУРИЛУУЛСАН:

ЭКИЛЕШИЯ ХХК-НЫГ ТӨЛӨӨЛЖ ИНЖЕНЕР / Г.ОЧИР /

2024 он.06.сар.12.өдөр

ШАЛГАЖ БАТАЛГААЖУУЛСАН:

АЙРАГ СУМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН /Г.БАТМАЙХАНТ /

2024 он.06.сар.14.өдөр

Зураг 12. Тоолуур баталгаажуулсан акт



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

УСНЫ ТООЛУУРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ

№ ЭУ ...166219.....

..........0..........-д

(хэрэглэгчийн нэр)

ашиглаж байгаа .......LXLC-100.... загварын ..........100.0.......... м³/ц хэмжих хязгаартай, ..100... мм-ийн голчтой № ..........23112064.............. -ын халуун, хүйтэн усны тоолуурыг №..................020........ лацаар битүүмжилж

(доогуур зурах)

..........2026... оны ..........06....... -р сарын ..........07..... -ны өдөр хүртэл улсын баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: ..............000001.............м³

Лабораторийн тэмдэг

Улсын шалгагчийн гарын үсэг, тэмдэг

2024... оны .....06р сарын .07... -ны өдөр

Зураг 13. Тоолуурын гэрчилгээ

# 3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

## 3.1. Шимт хөрсний овоолгыг хадгалах, хамгаалах

Шимт хөрсний хуулалтын MNS 5916:2008 “Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” стандартын дагуу хийж гүйцэтгэж овоолго байгуулан, хадгалж байна.




**Зураг 14. Уурхайн зохион байгуулалт**

## 3.2. Нөхөн сэргээлтийн бэлтгэл ажил

Орон нутгийн Байгаль орчны байцаагчаас техникийн нөхөн сэргээлт хийх газрыг сонгон авч зардлыг болон техник хэрэгслийн сонголтыг оновчтой байхаар төлөвлөсөн.

## 3.3. Техникийн нөхөн сэргээлт

2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөндөө уурхайн 1-р хүдрийн биет дээр 1 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийхээр тусгагдсан. Гэвч 1-р хүдрийн биет дээр 2024 онд ашиглалтын нэмэлт хайгуулын ажлаар хүдрийн биетүүд нэмж илэрсэн тул техникийн нөхөн сэргээлт хийх боломжгүй болсон тул сумын Байгаль орчны асуудал хариуцан мэргэжилтнээс санал авч Айраг сумын нэгдсэн хог хаягдлын талбайд 1 га талбайг цэвэрлэж техникийн нөхөн сэргээлтийн ажлыг 2024 оны 11 сарын 05-07ны өдрүүдэд 2 хоногийн хугацаанд 1га талбайд орлуулан хийж гүйцэтгэсэн болно.

Тус ажлыг гүйцэтгэхэд: ковш-1, 2 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж 2 өдөрт нийт 1,482,000 төгрөгийн өртөг зарцуулсан байна.

**Хүснэгт 5. Нөхөн сэргээлт хийсэн талбайн байршил**

| X | Y |
|---|---|
| 45°46'40.95"N | 109°16'33.72"E |
| 45°46'41.02"N | 109°16'38.49"E |
| 45°46'44.45"N | 109°16'38.19"E |
| 45°46'44.25"N | 109°16'33.75"E |




Зураг 15. Нөхөн сэргээлт хийсэн талбай



Зураг 16. Нөхөн сэргээлт хийхээс өмнө



**Зураг 17. Нөхөн сэргээлт хийсний дараа**

### 3.4. Биологийн нөхөн сэргээлтийн ажил

Биологоийн нөхөн сэргээлтийн ажил төлөвлөөгүй

## 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ

### 4.1. Тэрбум мод төлсийн хүрээнд 500ш мод тарих

Тэрбум мод төслийн хүрээнд 2024 оны 5 сард Дорноговь аймгийн Айраг сумын баруун суурьшлийн хэсэгт гаалийн талбайд 500ш хайлаас тарьж ургуулсан.





# 5. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

## 5.1. Амьтдын тоо толгой буурах, дайжих, амьдрах орчин устах, идэш тэжээл хомсдохоос хамгаалах

“Экилешия” ХХК компани нь 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөндөө дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд 2024 оны 5 сард уурхайгаас Айраг сумын хооронд малын сэг зэм устгах ажлыг хийж гүйцэтгэсэн болно.

Тус ажлыг гүйцэтгэхэд: ковш-1, хово-1ш, 4 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж нийт 7,780,000 төргөрийн өртөг зарцуулсан байна.






**5.2. Биологийн олон янз байдлын менежментийн арга хэмжээг тодорхойлох (Нэн ховордсон ургамлын нүүлгэн шилжүүлэх)**

Уурхайн талбайн хойд хэсэгт (45°40'17.57"N 109° 7'13.90"E) ургамлын судалгаа хийж гүйцэтгэсэн. Хээрийн судалгааны үр дүнг үндэслэн тодорхойлоход Монгол өвс-хазаар өвст бэлчээрийн төрөл тархсан байна. Мөн 1м2 талбайн бүрхэц 25%, ургамлын дундаж өндөр 15 см байна. Үүнээс говийн бүсийн нэн ховор ургамал болох зүүнгарын буюу улаан гоёо, аргамжин цэцэг, чонон хармаг гэх мэт ургамал бүртгэгдээгүй.



**Зураг 18. Раменскийн 1м2-ийн хэмжээст тор**




**Зураг 19. Ургамлын судалгаа хийсэн байршилын сансрын зураглал**

**Хүснэгт 6. Раменскийн 1м2 торнд зонхилж буй ургамал**

| Зонхилж буй ургамал | | |
|---|---|---|
| **№** | Шинжлэх ухааны нэр | Монгол нэр |
| **1** | Stripa gobica Roshev | Говийн хялгана |
| **2** | Cleistogenes songorica | Зүүн гарын хазаар өвс |
| **3** | Allium polyrrhizum | Таана |
| **4** | Allium mongolicum | Хөмүүл |

## 6. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөөгүй

## 7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ төлөвлөөгүй

## 8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө 2024 онд төлөвлөөгүй

# 9. ХОГ ХАЯГДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

## 9.1. Хатуу хог хаягдлын ангилан ялгах түр цэг байгуулах

Ахуйн хатуу хог хадгалах болон аюултай хог хаягдал хадгалах түр цэг тэмдэглэгээ байршуулсан.

Хог хаягдлыг дараах байдлаар ангилан ялгадаг:

- Аюултай хог хаягдал (Клийн Ойл ХХК гэрээ байгуулсан)
- Хуванцар сав (Жилийн хугацаанд хуримтлуулсны дараа дахивар авах цэгт нийлүүлнэ)
- Ахуйн хог хаядал (Сум орон нутагтай гэрээ байгуулсан)



Зураг 20. Хог хаягдлын цэг

МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

ТАТВАР ТӨЛСӨН БАРИМТ № - 2241101988309

| | |
|---|---|
| ТТД / Регистр: | 78900826548 / 9026762 |
| Татвар төлөгчийн нэр: | Дорноговь аймгийн Айраг сумын Засаг даргын тамгын газар |
| Татварын төрөл: | 01030723 - Хог хаягдлын үйлчилгээний хураамж |
| Харъяалах татварын алба: | Дорноговь / Айраг |
| Төлсөн дүн: | 1,200,000.00 ₮ |
| Гүйлгээний огноо: | 2024-11-22 17:34:38 |
| Гүйлгээний утга: | 2241101988309; ; 5411726; ; Дорноговь аймгийн Айраг сумын Засаг даргын тамгын газар; 99926190;Төрийн банк БАНКНЫ ТӨВ ГЯЛС БАНК 3.0;99926190 |
| Татварын данс: | До.Ай Хог хаягдлын хураамж - 100060100947 |
| Төлөлтийн хэлбэр: | Төрийн банк |

Зураг 21.Хог хаягдлын төлбөр төлсөн баримт

### 9.2. Ахуйн хэрэглээнээс гарах хог хаягдлыг зайлуулах гэрээг айраг сумын ТҮК-тай байгуулж сумын нэгдсэн хогийн цэгт тогтмол зөөвөрлөх

Ахуйн хог хаягдлыг Айраг сумтай гэрээ хийж уурхайн хогийн цэгт хэт их хогны хуримтлал үүсхээс сэргийлж тогмол зөөвөрлөн Айраг сумын нэгдсэн хогийн цэгт зайлуулдаг.

БАТЛАВ:
АЙРАГ СУМЫН ЗАСАГ ДАРГА
.........(С. ЖАРГАЛСАЙХАН)
2024 оны .5.. сарын .16..ны өдөр

**ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ**

2024 оны 05 сарын 16-ний өдөр № 10 Цагаандөрвөлж

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2,6 дахь хэсэг, Ариун цэврийн тухай хуулийн 17 дугаар зүйл, Хог хаягдлын тухай хуулийн 9.2, 20.1, 20.2 дугаар зүйл, сумын ИТХ-ийн 2019 оны 11-02 тоот тогтоолыг үндэслэв.

Хүний эрүүл мэнд хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, дахин боловсруулж эргүүлэн ашиглах, тээвэрлэх булах болон орчны ариун цэврийг тогтмол цэвэр байлгах, цэвэр эрүүл орчинд ажиллаж амьдрах орчныг бий болгоход оршино.

**Хоёр. Гэрээ байгуулагч талууд**

Нэг талаас Дорноговь аймгийн Айраг сумын ЗДТГ-ыг төлөөлж БОАХМ мэргэжилтэн Г.Батмайхант нөгөө талаас **“Экилешия”** ХХК (регистр дугаар 5411726 ) захирал Кан Мин Хо нар харилцан тохиролцож 2024 оны ахуйн хог хаягдлын гэрээг байгуулав.

**Гурав. Төлбөр тооцсон байдал:**

Айраг сумын ИТХ-ийн 2020 оны 12 сарын 16 ны өдрийн 02-09 тоот тогтоолын хавсралтын 11-ийн 3-р хүснэгтэнд зааснаар тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжид ноогдох сарын төлбөр талбай тус бүрт 100 000 төгрөгөөр тооцов.

Сарын төлбөр: 100 000 төгрөг

Жилийн нийт төлбөр: 1 200 000 төгрөг

**Дөрөв. Сумын ЗДТГ-ын эрх**

1. Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Ариун цэврийн тухай хуулийн дагуу хяналт тавьж ажиллах
2. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдал гаргасны төлбөрийг төвлөрүүлэх
3. Иргэд, аж ахуйн нэг, байгууллага хог хаягдлаа зориулалтын цэгт хаяж байгаа эсэхэд хяналт тавих
4. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх хуваарийг тээвэрлэгчтэй гэрээ байгуулж хэрэгжилтэд хяналт тавих

**Тав. Иргэн, ААН байгууллагын эрх үүрэг**

1. Өөрийн байгууллагын үйл ажиллагаанаас гарсан ахуйн, хуурай хог хаягдлыг стандартын шаардлага хангасан зориулалтын саванд хадгалж байх
2. Аж ахуйн нэгж байгууллага нь хог хаягдал гаргасны төлбөрөө улирал бүрийн сүүл сарын 15-ны өдрийн дотор гэрээнд зааснаар Төрийн сан банкны **100060100947** тоот дансанд тогтмол шилжүүлж байна.
3. Хог хаягдлыг ангилан ялгаж байх
4. Ахуйн болон үйлдвэрлэлийн хогийг тогтсон хугацаанд цэвэрлэж, хог хаягдлын талаархи дүрэм журам, стандартын шаардлагыг хангаж зориулалтын цэгт хаяж байхад анхаарах
5. Үйлдвэр үйлчилгээний явцад үүсэх хог хаягдлын хэмжээ, бусад мэдээллийг Засаг даргын тамгын газарт мэдээлж байх
6. Хог хаягдлыг ангилан хаях талаар зохих мэдээллийг ажилчиддаа эзэмшүүлж, сургалт сурталчилгаа явуулах, аюулгүй ажиллагааг хангаж ажиллах
7. Оршин суугаа газар орчмын хог хаягдлыг цэвэрлэх, олон нийтийг хамарсан ажилд оролцох
8. Хуульд заасан журмын дагуу олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шаардах
9. Үүссэн аюултай хог хаягдал, түүний эх үүсвэрийн талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагад мэдээллэх, тусгай зориулалтын цэгт устгах

**Зургаа. Гэрээний хариуцлага**

1. Аж ахуйн нэгж байгууллага нь хог хаягдал гаргасны төлбөрөө удаан хугацаагаар төлөөгүй болон ил задгай хог шатаасан, зориулалтын бус газар хог хаягдал хаясан нөхцөлд өр авлагыг барагдуулах ба учруулсан хохирлыг арилгах ба шаардлагатай тохиолдолд холбогдох дээд шатны байгууллагад хандан хог хаягдлын тухай хуулийн дагуу хариуцлага тооцно.
2. Аж ахуйн нэгж байгууллага нь энэхүү гэрээнд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл хоёр талын хамтарсан төлөөлөгч тухай бүр шийдвэрлэнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

ДОРНОГОВЬ АЙМГИЙН АЙРАГ СУМЫН ЗДТГ-ЫН БОАХМ
...................(Г.БАТМАЙХАНТ)
Утас: 88101941

"ЭКИЛЕШИЯ" ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ ЗАХИРАЛ
...................(КАН МИН ХО)
Утас: 91997204, 94447204

Зураг 22. Хог хаягдлын гэрээ

**9.3. Хог түр хадгалах цэгт цугларсан хогийг тогтмол хугацаанд зөвшөөрсөн цэгт тээвэрлүүлж байх**

Ахуйн хог хаягдлыг уурхайн хогийн цэгт төвлөрүүлэн Айраг сумын нэдсэн хогийн цэгт тээвэрлэж зайлуулдаг.

# 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

## 10.1. Агаарын тоос тоосонцор (PM2.5, PM10)

PM2.5 PM10 тоосыг хэмжих **CEM-DT-96** маркийн тоос хэмжигч багажаар 9 дугаар сарын 15нд хэмжилт хийсэн. Хэмжилтийг 24 цагийн хугацаанд 4 цагийн давтамжтай агаарын тоосжилтийг хэмжиж, график үзүүлэлт гаргалаа.






Зураг 23. CEM-DT-96 зөөврийн тоос хэмжигч багаж болон сертификат

| Үзүүлэлт | |
|---|---|
| **Ширхэглэл хэмжигч** | |
| Хэмжих хүрээ | 2.5,10 μм |
| Массын концентрац | PM2.5:0～500 μгр/м3;PM10:0～500 μгр/м3 |
| Нарийвчлал | 1 μгр/м3 |
| **Агаарын темпратур хэмжигч** | |
| Агаарын темпратур хэмжих хязгаар | 0-с 50°C/32-с 122°F |
| Нарийвчлал | ±1°C/2°F |
| Хэмжих чийгшлийн хязгаар | 0 -с 100%RH |
| Нарийвчлал | ±5%RH @0-с 20%RH болон 80-с 100%RH<br>±3.5%RH @20-с 80%RH |

| Огноо | Хугацаа/ байршил | Тээврийн зам-1 | | Тээврийн зам-2 | | Уурхайн карьер №1 | | Кемп | | Уурхайн карьер №2 | | ШТС | | Авто зогсоол | | Шимт хөрсний овоолго | | Хүдрийн овоолго | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2024.09.15 | | pm2.5 | pm10 | pm2.5 | pm10 | pm2.5 | pm10 | pm2.5 | pm10 | pm2.5 | pm10 | pm2.5 | pm10 | pm2.5 | pm10 | pm2.5 | pm10 | pm2.5 | pm10 |
| | 10:00 | 12 | 22 | 10 | 32 | 32 | 51 | 1 | 3 | 13 | 15 | 5 | 8 | 15 | 12 | 8 | 7 | 15 | 35 |
| | 14:00 | 8 | 25 | 12 | 25 | 25 | 47 | 2 | 5 | 20 | 12 | 2 | 7 | 10 | 16 | 7 | 8 | 20 | 40 |
| | 18:00 | 15 | 35 | 10 | 41 | 19 | 35 | 0 | 1 | 16 | 12 | 5 | 8 | 8 | 18 | 7 | 10 | 12 | 30 |
| | 20:00 | 2 | 15 | 9 | 15 | 21 | 30 | 0 | 0 | 8 | 15 | 4 | 15 | 15 | 12 | 9 | 12 | 19 | 32 |
| Дундаж | | **10** | **28** | **10** | **28** | **24** | **41** | **0.75** | **2.25** | **14.25** | **13.5** | **4** | **9.5** | **12** | **14.5** | 7.75 | 9.25 | 16.5 | 34.25 |
| Стандарт 24 | | 25 | 50 | 25 | 50 | 25 | 50 | 25 | 50 | 25 | 50 | 25 | 50 | 25 | 50 | 25 | 50 | 25 | 50 |







**Зураг  24. 2024 оны 9 сарын 15ны өдрийн PM2.5 PM10 тоосонцрын хэмжилтийн үр дүн**

2024 оны 09 дүгээр сарын 15н өдрийн PM2.5 PM10 тоос тоосонцрын хэмжилтийн үр дүнгээр харахад уурхайн карьер№1-т pm2.5 pm10 утга зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан үзүүлэлттэй байна.

**10.2. Усны хими, физикийн үзүүлэлт Микробиологийн үзүүлэлт**

Уурхайн шүүрлийн усны шинжилгээг 2024 оны 10 сарын 24ны өдөр авч ШУА Газарзүй-Геоэкологийн хүрээлэн усны шинжилгээний лабораториор шинжлүүлэн усны химийн үзүүлэлтийг тодорхойлуулсан/шинжилгээний дүнг хавсаргав/.

| Анион | 1 дм3 -д байгаа | | | Катион | 1 дм3 -д байгаа | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мг | мг-экв | мг-экв% | | мг | мг-экв | мг-экв% |
| Cl- | 102.2 | 2.88 | 10.2 | $Na^{+}+K^{+}$ | 224.8 | 9.77 | 34.5 |
| SO4- | 175.0 | 3.65 | 12.9 | $Ca^{++}$ | **253.3** | 12.64 | 44.6 |
| NO2- | 0.20 | 0.00 | 0.0 | $Mg^{++}$ | **72.0** | 5.92 | 20.9 |
| NO3- | 20.0 | 0.32 | 1.1 | $NH_4^{+}$ | 0.3 | 0.02 | 0.1 |
| CO3- | 0.0 | 0.00 | 0.0 | $Fe^{++}$ | 0.0 | 0.00 | 0.0 |
| HCO3- | 1,311.5 | 21.50 | 75.8 | $Fe^{+++}$ | 0.05 | 0.00 | 0.0 |
| Дүн | 1,608.9 | 28.35 | 100.0 | Дүн | 550.4 | 28.35 | 100.0 |
| $HCO_3^-$-ийн хагасыг хассан анионы катионуудын нийлбэр: 1503.6 мг/дм3 | | | | Анион катионуудын нийлбэр: **2159.4** мг/дм3 | | | |

| | |
|---|---|
| **Ерөнхий хатуулаг** | 18.56 мг-экв/ дм3 |
| **pH** | 6.29 |
| **Исэлдэх чанар** | 1.44 мг/ дм3 |
| **EC** | 2400 qS/cm |
| **TDS** | 1440 ppm |
| **Физик шинж чанар** | |
| **Тунгалаг** | 0 см |
| **Өнгө** | Цайвар бор |
| **Үнэр** | Үгүй |
| **Амт** | *** |
| **Тунадас** | Бор |
| **Булингар** | 59.8 NTU |

**Усны шинжилгээний дүгнэлт:**

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальци-натрийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувд давсархаг, маш хатуу, сул хүчиллэг орчинтой, эрдэсжилт, хатуулаг ихтэй, булингартай ус байна.

**10.3. Хөрсний шинжилгээ /Жилд 1 удаа/**

2024 ны 10 сарын 25ны өдөр хөрсний дээжийг Ил уурхайн карьер№1, Ил уурхайн карьер №2, засварын газар, авто зогсоол, ШТС, кемп нийт 6 цэгээс авч “Инженер Геодези” ХХК-ийн магадлан итгэмжлэгдсэн лабораторит хүргүүлэн хүнд металлын агууламж болон агрохими шинжлүүлэв. Шинжилгээний үр дүнгээс харахад зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан үзүүлэлт байхгүй байв/Шинжилгээний хариуг хавсралтаар оруулав/.




**Зураг 25. Уурхайн карьер №1-ээс авсан хөрсний химийн шинжилгээний үр дүнг харуулсан график**




**Зураг 26. Уурхайн карьер №2-оосс авсан хөрсний химийн шинжилгээний үр дүнг харуулсан график**




**Зураг 27. Засварын газраас авсан хөрсний дээжийн хүнд металлын агууламжийн үр дүнг харуулсан график**




**Зураг 28. Авто зогсоолоос авсан хөрсний дээжийн хүнд металлын агууламжийн үр дүнг харуулсан график**




**Зураг 29. ШТС авсан хөрсний дээжийн хүнд металлын агууламжийн үр дүнг харуулсан график**




**Зураг 30. Кемпээс авсан хөрсний дээжийн хүнд металлын агууламжийн үр дүнг харуулсан график**

### 10.4. Дуу чимээ

Дуу шуугианы түвшинг тодорхойлох хэмжилтийг хийхдээ Монгол улсын стандарт MNS 5003:2000 буюу “Шуугиан хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага”-ын 3.8-д заасны дагуу хэмжилт тус бүр нь 10 минут үргэлжилсэн гурван хэмжилтийг нийт хугацаа 30 минутаас багагүй хугацаанд хийж гүйцэтгэв.

Энэхүү судалгааг хийхдээ төслийн талбайд Япон улсад үйлдвэрлэсэн CEM, DT820 маркийн дуу шуугиан хэмжигч багажаар хэмжилтийг 3-5 удаа хийж үр дүнг дундажлан тооцоолов.

| № | Хэмжилт хийсэн газар | Дууны түвшиний доод утга, дб | Дууны түвшиний дунд утга, дб | Дууны түвшиний дээд утга, дб |
|---|---|---|---|---|
| 1 | Тайван байх үед | 49.9 | 53.5 | 60 |
| 2 | Тоног төхөөрөмж ажиллаж байх үед | 58.9 | 65.8 | 71.6 |
| **3** | Тээврийн зам дагуу | 55.9 | 61.1 | 63,5 |

Судалгааны явцад хэмжсэн цэгүүдийн утга зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс даваагүй боловч үйлчлэлийн хугацаа удаан байх тохиолдолд хүн болон тухайн орчинд дуу, чимээний үргэлжилсэн бохирдлыг үүсгэх юм.

# 11. УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БАЙГАЛЬ ОРЧИНД ХЭРХЭН НӨЛӨӨЛЖ БАЙГАА НӨЛӨӨЛӨЛ БОЛОН СӨРӨГ НӨЛӨӨГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭГ ХЭРХЭН АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН, ХЯНАЛТ МОНИТОРИНГИЙН ЯВЦЫГ ТАНИЛЦУУЛАХ

## 11.1. Орон нутгийн Байгаль орчны газарт

2024 оны 12 сарын 18ны өдөр Дорноговь аймгийн Байгаль орчны газраас ажлын хэсэг уурхай дээр ажилласан.

## 11.2. Орон нутаг олон нийтэд танилцуулах

"Экилешия" ХХК уурхайн үйл ажиллагаа байгаль орчинд хэрхэн нөлөөлж байгаа нөлөөлөл болон сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээг хэрхэн авч хэрэгжүүлсэн ажлын явцыг Дорноговь аймгийн Айраг сумын БИНХ-тай уялдуулан 2024 оны 12 сардаа багтаан танилцуулна.

## 11.3. Бүх шатны Засаг дарга, Байгаль орчны улсын байцаагч, орон нутгийн байцаагч

2024 оны 12 сарын 18ны өдөр Дорноговь аймгийн Байгаль орчны газраас ажлын хэсэг уурхай дээр ажилласан ба орон нутгийн байгаль орчны байцаагч байлцсан болно.

## 11.4. Төрийн захиргааны байгууллагт танилцуулах

2024 оны 11 сарын 01ны өдөр www.eic.mn-д БОМТ-ний биелэлтийн тайланг байршуулсан.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

| № | Тайлант он | Төсөл хэрэгжүүлэгчийн РД | Төсөл хэрэгжүүлэгчийн нэр | Төслийн нэр | Төслийн байршил | Мэдээний төлөв байдал | Мэдээ илгээсэн огноо, хугацаа | Аймаг, нийслэлийн түвшинд мэдээ хянасан огноо, хугацаа | Мэдээ хувиарласан огноо, хугацаа | Мэдээ хянасан огноо, хугацаа | Мэдээ баталсан огноо, хугацаа |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2024 | 5411726 | "Экилешия" ХХК | "Жоншт Толгойн хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах" төсөл | Дорноговь аймаг, Айраг сум, Нарт багийн нутагт байрлана. | илгээсэн | 2024-11-05 09:51:19 | 2024-07-23 11:08:31 | 2024-07-25 09:23:13БОУАӨЯ - Солонго | 2024-07-25 11:13:28 | |

## 12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ЗАРДАЛ

| № | ТӨЛӨВЛӨГӨӨ | ТӨЛӨВЛӨСӨН ЗАРДАЛ | БИЕЛЭЛТ |
|---|---|---|---|
| **1** | Сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээний биелэлт | 500,000 | 10,883,688 |
| **2** | Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний биелэлт | 500,000 | 7 780 000 |
| **3** | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт | 6,800,000 | 1 482 000 |
| **4** | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 500,000 | 1,700,000 |
| **5** | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт | 1,200,000 | 1,300,000 |
| **6** | Тэр бум мод төслийн хүрээнд | 500,000 | 5,712,700 |
| Нийт зардал | | **10,000,000** | **28,858,388** |

# ХАВСРАЛТ

1. ААН гэрчилгээ
2. Тусгай зөвшөөрөл
3. Хог хаягдлын гэрээ
4. Аюултай хог хаягдал устгах гэрээ
5. Ус ашиглах гэрээ
6. Ус бохирдуулсны төлбөрийн гэрээ
7. Хөрсний шинжилгээ
8. Усны шинжилгээ

## ААН гэрчилгээ



УБ-2

Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 20 дугаар тогтоолоор батлав.

МОНГОЛ УЛС

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000007111

2010.10.05
/Бүртгэсэн он, сар, өдөр/

9011254020
/Улсын бүртгэлийн дугаар/

5411726
/Регистрийн дугаар/

Экилешия Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр/

Дүрэм
/Үүсгэн байгуулах баримт бичиг/

Шийдвэр — /шийдвэрийн нэр/; 01 — /дугаар/; 2010.10.04 — он, сар, өдөр

511000 /код/ — Гадаад худалдаа /Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

809000 — Орчуулгын үйлчилгээ

511001 — Худалдааны зуучлал

712900 — Тоног төхөөрөмжийн түрээс

/код/ — /Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

Хугацаагүй — хугацаа; 1 — /гишүүдийн тоо/; 1,000.0 — /өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр/

Баянгол, 14-р хороо, 3-р хороолол, 11 - 34 тоот, утас1:91917204, утас2:96067204, факс:
/хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

Улсын бүртгэлийн ерөнхий газрын
Хуулийн этгээдийн бүртгэлийн газар

УХА0463

**Харилцах банкны бүртгэл:**

| Харилцагч банкны нэр | Дансны төрөл | Дансны дугаар | Бүртгэсэн ажилтан, тэмдэг |
|---|---|---|---|
| Голомт төв банк | Төгрөгийн | 2405003361 | М.Б… |
| Голомт төв банк | Валютын | 2405003360 | [illegible] |

**Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн бүртгэл:**

| Д/д | Нэмэлт, өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан, тэмдэг |
| 1 | [illegible] бүртгэв | 2012.06.29 | Э.Эрдэнэ… |
| 2 | 0899 Ашигт малтмалын ашиглалт эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв | 2012.09.18 | Ш.Цэнгэл |
| 3 | 0899 Ашигт малтмалын ашиглалт эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв. | 2012.09.18 | Ш.Цэнгэл |
| 4 | Ажиллах хугацааг 2012.09.05 -ний өдрөөс 2013.09.05 -ний өдөр хүртэл сунгасныг бүртгэв. | 2012.09.18 | Ш.Цэнгэл |
| 5 | Ажиллах хугацааг 2013.09.06 -ний өдрөөс 2014.09.05 -ний өдөр хүртэл сунгасныг бүртгэв. | 2013.09.06 | [illegible] |
| 6 | Ажиллах хугацааг 2014.09.06 -ний өдрөөс 2015.09.05 -ний өдөр хүртэл сунгасныг бүртгэв. | 2014.08.13 | Н.Цэнгүүнсүрэн |
| 7 | Өөрийн хөрөнгийн хэмжээ 179000 мян.төг-р нэмэгдэж нийт 180000 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв. | 2016.02.04 | Д.Лхаса |
| 8 | Хувь нийлүүлэгчээс 1 нэмэгдэж, 1 хасагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2016.06.21 | О.Шижиртуяа |
| 9 | Санжаадорж овогтой Сугар -г захирал-р томилсныг бүртгэв. | 2016.06.21 | О.Шижиртуяа |
| 10 | Улаанбаатар, Баянгол, 1-р хороо, , , , Газар бизнес төв 400 тоот, Утас1 70000083, Утас2 , Факс хаягийг шинээр бүртгэв. | 2016.06.21 | О.Шижиртуяа |
| 11 | Хувь нийлүүлэгчээс 1 нэмэгдэж, 1 хасагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2019.08.07 | Д.Ганзаморон |
| 12 | Хувьцаа эзэмшигч 1 нэмэгдэж 1 хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв. | 2020.01.08 | У.Мандахтуяа |
| 13 | Kang овогтой Min Ho-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв. | 2021.09.24 | Н.Энхтуяа |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

## Тусгай зөвшөөрөл

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

### АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ

# ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар ***MV-014111***

Ашигт малтмалын тухай Монгол Улсын хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн

***Дорноговь*** аймаг /хот/-ийн

***Айраг*** сум /дүүрэг/-ын

***Жонш толгой*** нэртэй газарт орших

***38.41*** гектар талбай бүхий уурхайн талбайд хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглахыг зөвшөөрч улсын бүртгэлийн ***9011254020*** тоот гэрчилгээтэй

***“Экилешия” ХХК*** -д

энэхүү тусгай зөвшөөрлийг ***2038.09.05*** дуустал хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавсралтгүй бол хүчингүй.

ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН КАДАСТРЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.БАТМАГНАЙ

202[illegible] оны 05 сарын 11 өдөр

Улаанбаатар хот

0000545

## Хог хаягдлын гэрээ

БАТЛАВ:
АЙРАГ СУМЫН ЗАСАГ ДАРГА
........ (С. ЖАРГАЛСАЙХАН)
2024 оны 5 сарын 16-ны өдөр

### ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ

2024 оны 05 сарын 16-ний өдөр № 10 Цагаандэрвэлж

**Нэг. Нийтлэг үндэслэл**

Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2,6 дахь хэсэг, Ариун цэврийн тухай хуулийн 17 дугаар зүйл, Хог хаягдлын тухай хуулийн 9.2, 20.1, 20.2 дугаар зүйл, сумын ИТХ-ийн 2019 оны 11-02 тоот тогтоолыг үндэслэв.

Хүний эрүүл мэнд хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, дахин боловсруулж эргүүлэн ашиглах, тээвэрлэх булах болон орчны ариун цэврийг тогтмол цэвэр байлгах, цэвэр эрүүл орчинд ажиллаж амьдрах орчныг бий болгоход оршино.

**Хоёр. Гэрээ байгуулагч талууд**

Нэг талаас Дорноговь аймгийн Айраг сумын ЗДТГ-ыг төлөөлж БОАХМ мэргэжилтэн Г.Батмайхант нөгөө талаас **“Экилешия”** ХХК (регистр дугаар 5411726 ) захирал Кан Мин Хо нар харилцан тохиролцож 2024 оны ахуйн хог хаягдлын гэрээг байгуулав.

**Гурав. Төлбөр тооцсон байдал:**

Айраг сумын ИТХ-ийн 2020 оны 12 сарын 16 ны өдрийн 02-09 тоот тогтоолын хавсралтын 11-ийн 3-р хүснэгтэнд заасанаар тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжид ноогдох сарын төлбөр талбай тус бүрт 100 000 төгрөгөөр тооцов.

Сарын төлбөр: 100 000 төгрөг

Жилийн нийт төлбөр: 1 200 000 төгрөг

**Дөрөв. Сумын ЗДТГ-ын эрх**

1. Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Ариун цэврийн тухай хуулийн дагуу хяналт тавьж ажиллах
2. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдал гаргасны төлбөрийг төвлөрүүлэх
3. Иргэд, аж ахуйн нэг, байгууллага хог хаягдлаа зориулалтын цэгт хаяж байгаа эсэхэд хяналт тавих
4. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх хуваарийг тээвэрлэгчтэй гэрээ байгуулж хэрэгжилтэд хяналт тавих

**Тав. Иргэн, ААН байгууллагын эрх үүрэг**

1. Өөрийн байгууллагын үйл ажиллагаанаас гарсан ахуйн, хуурай хог хаягдлыг стандартын шаардлага хангасан зориулалтын саванд хадгалж байх
2. Аж ахуйн нэгж байгууллага нь хог хаягдал гаргасны төлбөрөө улирал бүрийн сүүл сарын 15-ны өдрийн дотор гэрээнд заасанаар Төрийн сан банкны **100060100947** тоот дансанд тогтмол шилжүүлж байна.
3. Хог хаягдлыг ангилан ялгаж байх
4. Ахуйн болон үйлдвэрлэлийн хогийг тогтсон хугацаанд цэвэрлэж, хог хаягдлын талаархи дүрэм журам, стандартын шаардлагыг хангаж зориулалтын цэгт хаяж байхад анхаарах
5. Үйлдвэр үйлчилгээний явцад үүсэх хог хаягдлын хэмжээ, бусад мэдээллийг Засаг даргын тамгын газарт мэдээлж байх
6. Хог хаягдлыг ангилан хаях талаар зохих мэдээллийг ажилчиддаа эзэмшүүлж, сургалт сурталчилгаа явуулах, аюулгүй ажиллагааг хангаж ажиллах
7. Оршин суугаа газар орчмын хог хаягдлыг цэвэрлэх, олон нийтийг хамарсан ажилд оролцох
8. Хуульд заасан журмын дагуу олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх, хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шаардах
9. Үүссэн аюултай хог хаягдал, түүний эх үүсвэрийн талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагад мэдээллэх, тусгай зориулалтын цэгт устгах

**Зургаа. Гэрээний хариуцлага**

1. Аж ахуйн нэгж байгууллага нь хог хаягдал гаргасны төлбөрөө удаан хугацаагаар төлөөгүй болон ил задгай хог шатаасан, зориулалтын бус газар хог хаягдал хаясан нөхцөлд өр авлагыг барагдуулах ба учруулсан хохирлыг арилгах ба шаардлагатай тохиолдолд холбогдох дээд шатны байгууллагад хандан хог хаягдлын тухай хуулийн дагуу хариуцлага тооцно.
2. Аж ахуйн нэгж байгууллага нь энэхүү гэрээнд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл хоёр талын хамтарсан төлөөлөгч тухай бүр шийдвэрлэнэ.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| | |
|---|---|
| ДОРНОГОВЬ АЙМГИЙН АЙРАГ СУМЫН ЗДТГ-ЫН БОАХМ | "ЭКИЛЕШИЯ" ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ ЗАХИРАЛ |
| ……………………(Г.БАТМАЙХАНТ) | ……………………(КАН МИН ХО) |
| Утас: 88101941 | Утас: 91997204, 94447204 |

## Аюултай хог хаягдал устгах гэрээ

**БАТЛАВ:**
**“Клин ОЙЛ” ХХК-ИЙН**
**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**

**Б.МӨНХДОРЖ**

**БАТЛАВ:**
**“Экилешия” ХХК-ИЙН**
**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**

**Б.ЖАРГАЛСАЙХАН**

### ХИМИЙН ХОРТОЙ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ХАЯГДАЛ УСТГАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

№

2024 оны 6-р сарын 19-ны өдөр Улаанбаатар хот

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Нэг талаас “Клин Ойл” ХХК /цаашид гүйцэтгэгч гэх/ төлөөлж, Захирал Б.Мөнхдорж нөгөө талаас /цаашид захиалагч гэх/-ыг “Экилешия” ХХК-ийг төлөөлж Байгаль орчны мэргэжилтан албан тушаалтай И.Цэвэгмэд бид харилцан тохиролцож, Монгол Улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Байгаль орчны тухай хууль Монгол улсын шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан Химийн хорт болон аюултай бодис хадгалах, ашиглах, устгах журам болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

1.1. Захиалагч тал нь гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөх болон байгууллага хоорондын ажлын уялдааг сайжруулж хариуцлагыг дээшлүүлж, хамтран ажиллахад оршино.

### ХОЁР. ЗАХИАЛАГЧ ТАЛЫН ЭРХ ҮҮРЭГ

2.1. Захиалагч дараах эртэй:
2.1.1. Гүйцэтгэгч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй,
2.2. Захиалагч дараах үүрэгтэй:
2.2.1. Аюултай хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалтын дагуу аюултай хог хаягдал савлаж хадгалах сав нэг бүр нь “Аюултай хог хаягдал” гэсэн бичиглэлтэй, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй байх ба ил харагдахуйц газар тухайн хаягдлын нэр, хуримтлуулж эхэлсэн хугацааг заавал тэмдэглэсэн байх,
2.2.2. Үүсэн аюултай, эрсдэлтэй хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтын дагуу тасаг нэгжээс нэг цэгт цуглуулан, зориулалтын түр хадгалах байранд хадгалах,
2.2.3. Хадгалсан хог хаягдлыг хүлээлгэж өгөхдөө бодит хэмжээг бодитоор зөв хэмжих,
2.2.4. Захиалагчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн гүйцэтгэгчийн ажилтан бэртэж гэмтсэн, өртсөн, хордсоноос үүдэн гарах хохирлыг захиалагч бүрэн хариуцлага хүлээх,

### ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Гүйцэтгэгч дараах эрхтэй:
3.1.1. Захиалагч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй,
3.1.2. Хаягдлыг зориулалтын сав баглаа боодолтой, хаяг шошготой, аюултай тэмдэглэгээтэй байхыг шаардах хаягүй бол хүлээн авахгүй байх эрхтэй,
3.1.3. Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг шаардах эсвэл дагалдах бичиггүй бол хог хаягдлыг хүлээн авахгүй байх эрхтэй
3.2. Гүйцэтгэгч дараах үүрэгтэй:

3.2.1. Аюултай хог хаягдлыг хүлээн авах явцад хууль, журам, стандарт шаардлагад заасны дагуу ажиллах, ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хөдөлмөр аюулгүй байдлыг хангаж, бүрэн хүлээн авах, түүнээс үүдэх аливаа эрсдэл хариуцлагыг бүрэн хариуцах,

3.2.2. Гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн захиалагч болон гүйцэтгэгчийн ажилтан, бусад этгээд бэртэж гэмтэн, өртсөн, хордсоноос үүдэн гарах хохирлыг гүйцэтгэгч бүрэн хариуцах,

3.2.3. Аюултай хог хаягдалтай холбоотой зөрчил илэрсэн болон засаж сайжруулах шаардлагатай санал байгаа тохиолдолд мэдэгдэх,

3.2.4. Аюултай хог хаягдлыг зориулалтын устгалын төвд аюулгүй болгон устгах

3.2.5. Тухайн байгууллага дээр гарсан онцгой нөхцөл байдлын улмаас ажиллах тохиолдолд харилцан тохиролцож, гэрээнд заагдсаны дагуу үүргээ биелүүлэх үүрэгтэй. Шаардлагатай бол гэрээнд нэмэлт тодотгол оруулж болно.

## ДӨРӨВ. ХУГАЦАА, ТӨЛБӨР ТООЦОО

4.1. Устгах аргачлалын дагуу устгалын үед аюултай хог хаягдлын хэмжээнээс хамааран, устгал өгөх ба аюултай хог хаягдлыг үнэ төлбөргүй шилжүүлэн авна. Аюултай хог хаягдлын устгалын хүлээн авч устгуулагч талд баримт бүрдүүлж өгнө.

## ТАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

5.1 Үйл ажиллагаандаа дагаж мөрдөх дүрэм журмыг мөрдөөгүйгээс гэрээнд оролцогч талуудад гэм хор учирсан бол буруутай тал нь хариуцлагыг бүрэн хүлээнэ.

## ЗУРГАА. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

6.1. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр, сүлжээний хэвийн ажиллагааны горимоос хэтэрсэн гэнэтийн огцом ачаалал зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах, тэдгээрийн хяналтаас гадуур, урьдчилж тооцох ба даван туулах боломжгүй шалтгаануудыг ойлгоно.

6.2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нэн даруй нөгөө талдаа мэдэгдэнэ. Энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар хойшлогдоно.

6.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал үүссэн тухай тодорхойлолтыг холбогдох эрх бүхий байгууллагаас гаргуулж авна. Энэ тохиолдолд Талууд харилцан тохиролцож асуудлыг шийдвэрлэнэ.

6.4. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээний үүргээ биелүүлээгүй,эсвэл зохих ёсоор биелүүлээгүй тал нь энэ тухайгаа нотолсон тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөнө.

## ДОЛОО. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ

7.1. Талууд энэ гэрээг биелүүлэх явцад иргэний болон эрх зүйн маргаанд хамааргдах асуудлаар бие биедээ өгсөн зөвлөмжийг анхааралдаа авч ажиллана.

7.2. Энэхүү гэрээтэй холбоотой маргаан гарсан тохиолдолд талууд аль болох хэлэлцээрийн аргаар шийдэхийг эрмэлзэх бөгөөд эс эвлэрвэл захиалагчийн оршин байгаа газрын харьяаллаар Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

## НАЙМ. МЭДЭЭ, МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛЫГ ХАДГАЛАХ

8.1. Талууд энэхүү гэрээг байгуулсантай холбоотой болон гэрээг хэрэгжүүлэх явцад шууд болон шууд бусаар олж мэдсэн байгууллага, ажилтан ажиллагсад, харилцагч, үйлчлүүлэгчийн байгууллагын болон ажилтны хувийн нууцад хамааралтай (техник, санхүү, бизнес, хувь хүний

эрүүл мэндийн мэдээллийн нууц гэх мэт) аливаа мэдээ, мэдээллийг бусдад бичгэн, аман болон бусад хэлбэрээр задруулахгүй байх үүргийг хугацаагүй хүлээнэ.

8.2. Энэхүү гэрээний 8.1-д заасан нөхцөлийг зөрчсөн тал үүнтэй холбоотойгоор үүсэх аливаа үр дагавар, хохирлыг хуулийн дагуу арилгах үүрэг хүлээнэ.

## ЕС. ГЭРЭЭНИЙ БАТАЛГАА

9.1. Энэхүү гэрээний үндсэн эхийг хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгална.

9.2. Талууд харилцан тохиролцвол гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно

9.3. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах санал, хүсэлтийг бичгээр үйлдэж 10-аас доошгүй хоногийн өмнө нөгөө талдаа гэрээнд заасан хаягаар, баталгаат шуудангаар эсвэл биечлэн хүргүүлнэ.

9.4. Энэхүү гэрээ нь талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга дарсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээний хугацаа дуусах хүртэл хүчинтэй үйлчилнэ.

9.5. Гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг болно.

9.6. Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг гүйцэтгэх, мэргэжлийн туршлагатай ажилтан, зориулалтын ажил гүйцэтгэх, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн холбогдох хууль журмын дагуу шударгаар авсан бөгөөд тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаагүй болохыг үүгээр баталж байна.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| Гүйцэтгэгчийг төлөөлж: | Захиалагчийг төлөөлж: |
|---|---|
| Захирал албан тушаалтай | Байгаль орчны мэргэжилтан албан тушаалтай |
| ......................................./Б.Мөнхдорж/ | ......................................./И.Цэвэгмэд / |
| Утас: 99095728 | Утас: 99275568 |
| | : |

## Ус ашиглах гэрээ

БАТЛАВ:
Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч:
/С.ЭНХЗОРИГ/

БАТЛАВ:
“Экилешия”ХХК-ийн гүйцэтгэх захирал /ЖАНГ МИН ХО/

### УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2024 оны 06 дугаар сарын 04-ны өдөр Дугаар 11 Сайншанд сум

**Нэг.** Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу “Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаа”-ны 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 08 тоот ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж Дорноговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Усны нөөц, ашиглалт, хамгаалалт хариуцсан мэргэжилтэн Ширнэн овогтой Амгалансайхан, Ус ашиглагчийг төлөөлж Дорноговь аймгийн Айраг сумын төвөөс баруун урагш 30 км-зайд орших, улсын бүртгэлийн дугаар 9011254020 тоот гэрчилгээ, 5411726 тоот регистрийн дугаартай хайлуур жоншны хүдэр олборлох “Экилешия” ХХК-ийн Уулын инженер Ганбат овогтой Очир нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

**Хоёр.** Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт: Уурхайн хүн амын унд ахуйн хэрэгцээнд болон зам талбайн тоосжилт дарахад усны нөөцийг ашиглана. Зам талбайн усалгаанд шавхан зайлуулж буй усаа ашигладаг.

2.2. Ашиглах усны хэмжээ:

2.2.1. унд-ахуйд 1080,0 м$^3$ /жил/

2.2.2. уурхайгаас шавхан зайлуулах 10368,0 м$^3$ /жил/

2.3.Усны чанар, найрлага: Гүний худгийн уснаас улирал тутам дээж авч шинжилгээ хийлгэн шинжилгээний хариу болон дүгнэлтийг тухай бүрт нь Байгаль орчин аялал жуулчлалын газарт ирүүлнэ.

2.4. Усны эх үүсвэр болон байршил: 1 өрөмдмөл худагтай. Ундрага нь 1 л/с. Худгийн ус нь тунгалаг, хатуулаг 3мг/экв байгаа нь гидрокарбонат-магни-кальцийн төрөлд хамаарах бөгөөд технологийн усны хэрэгцээнд хэрэгдэж болно. Ажилчдын ундны усыг Айраг сумаас “Контейнр Айраг Терминал”ХХК-ын худгаас зөөвөрлөнө.

Худгийн координат:

Худгийн гүн нь 60м. Худагт QJD100 маркын насос 50 м-ын гүнд байрлуулсан. Тоолуур суурилуулаагүй.

Барилга байгууламж: Мэдээлэл байхгүй.

Тоног төхөөрөмжийн нэр, марк:
Хүчин чадал:

2.5. Хаягдал усны хэмжээ: Унд-ахуйн хэрэгцээний бохир усыг хөрсөнд нэвчүүлэн зайлуулна. 1080 $м^3$/жил/

Стандартын шаардлага: Хаягдал бохир усыг цэвэршүүлэн хүрээлэн буй орчинд нийлүүлэхдээ цэвэршүүлсэн бохир усны ерөнхий шаардлага /MNS-4943:2011/-ыг ханган ажиллана.

Хаях цэгийн байршил:

2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ: 1.5 кг/м3

Жинлэгдэх бодис, кг.......................................................................................................

Органик бодис, кг...........................................................................................................

Эрдэс бодис, кг...............................................................................................................

Хүнд металл, кг..............................................................................................................

Аюултай бохирдуулах бодис, гр.........................................................................................

2.7. Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин: Унд-ахуйн бохир усыг хөрсөнд нэвчүүлэн зайлуулна.

2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээг төлөвлөж ирүүлнэ.

2.9. Усны тоолуур:

Төрөл, нэр, дугаар:

2.10. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:

Дүгнэлт 17-д заасны дагуу нийт 11448,0 $м^3$ усны нөөцийн төлбөр 9302688,0 төг /есөн сая гурван зуун хоёр мянга зургаан зуун наян найман төгрөг/

2.11. Хаягдал усан дахь нэгж бохирдуулах бодист ногдох төлбөрийн хэмжээ:

**Гурав.** Талуудын эрх, үүрэг

Гэрээ байгуулагч талууд Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 28.4, 28.8, 30.1, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

**Дөрөв.** Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл, шинжилгээний үзүүлэлт, экологийн паспорт хөтлөх

/MNS 4219-94/ Заспийн газрын тогтоол, төлбөр тооцох аргачлал нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Гэрээний 2.3, 2.4, 2.6, 2.7, 2.8 дахь заалтуудад заагдсан чанар, найрлага, байршил, бохирдуулах бодисын хэмжээ, хаягдал ус хаях цэгийн байршил, ус хамгаалах арга хэмжээний талаарх мэдээллийг тусгайлан гаргаж Байгаль орчин, аялал жуулчлалын газарт ирүүлнэ.

4.4. Ус ашиглуулагч нь 2023 оны 11 дүгээр сарын 01-ний дотор ус ашиглалтын тайлан болон усны нөөц ашигласны төлбөрийн мэдээг хүлээн авч гэрээний биелэлтийг дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.5. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.6. Гэрээг Усны тухай хуулийн 17.1.9, 29.3 дахь заалтууд болон дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.

4.6.1. ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;

4.6.2 аль нэг тал татан буугдсан бол.

4.7. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| Ус ашиглуулагчийг төлөөлж: | Ус ашиглагчийг төлөөлж: |
|---|---|
| БОАЖГ-ын Усны асуудал хариуцсан мэргэжилтэн........../Ш.Амгалансайхан/ | "Экилешия"ХХК-ийн Уулын инженер............/Г.Очир/ |
| Хаяг: Дорноговь аймаг, Сайншанд хот, Төрийн өмчийн 3-р байр, 2 давхарт 206 тоот Харилцах утас:0252242726, 90990887 | Хаяг: Дорноговь аймаг, Даланжаргалан сум Харилцах утас: 97111113 |

## Ус бохирдуулсны төлбөрийн гэрээ

БАТЛАВ:
АЙРАГ СУМЫН ЗАСАГ ДАРГА
(С. ЖАРГАЛСАЙХАН)

2024 оны 5 дугаар сарын 15-ны өдөр

### ХАЯГДАЛ УСЫГ ШУУД НИЙЛҮҮЛЖ БАЙГАА ХУУЛИЙН ЭТГЭЭДТЭЙ БАЙГУУЛАХ УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ГЭРЭЭ

2024.05.15 Дугаар 01 Цагаандэрвэлж

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 24 дүгээр зүйл, 24.2 дахь хэсэгт заасны дагуу Умард говийн Гүвээт- Халхын талын Сав газрын захиргааны гаргасан 2024 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 11 дугаартай хаягдал ус хаях, зайлуулах дүгнэлтийг үндэслэн нэг талаас ус ашиглуулагчийг төлөөлж Айраг сумын Засаг Даргын Тамгын Газрын Байгаль орчны мэргэжилтэн Г.Батмайхант нөгөө талаас: Ус бохирдуулагчийг төлөөлж Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 14 дүгээр хороо, 3-р хороолол 11-34 тоот хаягт байрлах 9011254020 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ, 5411726 тоот регистрийн дугаартай хуулийн этгээдийг төлөөлж "Экилешия" ХХК- ийн захирал Кан Мин Хо нар ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөр төлөх талаар харилцан тохиролцон энэхүү гэрээг 1 (нэг) жилийн хугацаатай байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус бохирдуулагч нь хаягдал усыг Хүрээлэн байгаа орчин.Усны чанар.Хаягдал ус.Ерөнхий шаардлага MNS 4943:2015 стандартын норматив шаардлагад нийцүүлэн байгальд шууд нийлүүлнэ.

2.2. Ус бохирдуулагч нь Усны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усны чанарыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаардлагад нийцүүлэн ус бохирдуулсны төлбөр, стандартын норматив шаардлагад нийцүүлээгүй тохиолдолд ус бохирдуулсны төлбөрийг хаягдал усанд агуулагдах бохирдуулах бодисын хэмжээнээс хамааран 2-5 дахин шатлан өсгөх хэлбэрээр тооцож төлнө.

2.3. Төлбөр төлөгч нь Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу хаягдал усан дахь бохирдуулах бодист ногдох төлбөр, нөхөн төлбөрийг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор харъяалах татварын албанд төлнө.

**Органик бодис /ХХХ/**: 1,5кг/м$^3$*1080м$^3$/жил* 50 төг/кг =81,000

**Нийт дүн: 81,000 төг /Наян нэгэн мянган төгрөг/**

2.4. Ус бохирдуулагч нь дараах мэдээллийг улирал тутамд Сав газрын захиргаа, харъяа татварын албанд хүргүүлнэ. Үүнд:

2.4.1. Хаягдал ус нийлүүлдэг хүн, хуулийн этгээдийн нэр;

2.4.2. Цэвэрлэх байгууламж болон зөөврийн машинд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ;

2.4.3. Байгальд нийлүүлсэн хаягдал усны хэмжээ;

2.4.4.Хаягдал усанд байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор хийлгэсэн шинжилгээний дүн;

2.4.5. Бохирдуулах бодисын ялгарал шилжилтийн системд усны бохирдлын мэдээллийг бүртгүүлнэ;

2.4.6. Ус бохирдуулсаны төлбөр төлсөн тайлан;

Гурав. Ус ашиглуулагчийн эрх, үүрэг

3.1. Ус бохирдуулагчийг мэдээ, мэдээлэл, удирдлагаар хангаж, хяналт тавина.

3.2. Усны тухай хуулийн 17.1.8 дахь хэсэгт заасны дагуу Сав газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтад заасны дагуу Сум, дүүргийн Засаг дарга нь нутаг дэвсгэртээ хаягдал ус зайлуулах цэг тогтооно.

3.3 Сав газрын захиргаа болон сум дүүргийн Засаг дарга нь хаягдал усыг энэхүү гэрээний 2.1-д заасан стандартын норматив шаардлагад нийцүүлэн цэвэрлэсэн, дахин ашигласан ус бохирдуулагчийг ус бохирдуулсны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх жагсаалтыг гаргана.

3.4. Сав газрын захиргаа, сум дүүргийн Засаг дарга нь хаягдал ус хаях, зайлуулах шаардлагыг зөрчсөн ус бохирдуулагчийн хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг цуцална.

Дөрөв. Ус бохирдуулагчийн эрх, үүрэг

4.1. Ус бохирдуулагч нь Сав газрын захиргаанаас мэргэжил, арга зүйн зөвлөгөө авах, хаягдал ус хаях, зайлуулах цэг тогтоох, ногдуулсан ус бохирдуулсны төлбөр болон нөхөн төлбөрийн хэмжээг үндэслэлгүй гэж үзвэл дээд шатны байгууллагад гомдол гаргах эрхтэй.

4.2. Ус бохирдуулагч нь үйл ажиллагаандаа энэхүү гэрээг болон холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт, норм норматив, ТЭЗҮ, зураг төсөл, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг мөрдөж ажиллана.

4.3. Ус бохирдуулагч нь хаягдал усны ээлхүүнийг тодорхойлох хэмжих хэрэгсэл (тоолуур)-ийг "Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам"-д заасны дагуу хаягдал усны шугамын гаргалгаан дээр суурилуулах тоолуур нь гаргалгааны шугамын голчтой адил байх бөгөөд мэдрэгчийн хийц нь хаягдал усны найрлагаас хамааран өөрчлөгдөх, эвдрэх, гэмтэх, зэрэг эрсдэлээс хамгаалагдсан зд ангиар хийгдсэн байх шаардлагад нийцүүлэн суурилуулна.

4.4. Ус бохирдуулагч нь хаягдал усны дүгнэлтэд тусгагдсан шаардлага, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, зөвлөмжийн дагуу сумын Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулж хамтран ажиллах

Тав. Бусад

5.1. Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

5.2. Ус бохирдуулагч нь ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

5.3. Энэхүү гэрээг сунгах, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой асуудлыг 2 тал харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

5.4. Энэхүү гэрээтэй холбогдсон гарсан аливаа маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд эс тохиролцвол иргэний журмаар шүүхээр шийдвэрлүүлнэ.

Зургаа. Давагдашгүй хүчин зүйлс

6.1. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл (тухайлбал: газар хөдлөлт, үер, гал түймэр, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт гэх мэт)-ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас (нөхөн төлбөр, торгууль) чөлөөлөгдөх болно.

6.2. Ус бохирдуулагч нь давагдашгүй хүчин зүйл бий болсныг нотолно.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| Ус ашиглуулагчийг төлөөлж: | Ус ашиглагчийг төлөөлж: |
| --- | --- |
| Дорноговь аймгийн Айраг сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны мэргэжилтэн ………………………… (Г.Батмайхант)<br>Хаяг: Монгол улс, Дорноговь аймаг, Айраг сум, 4 дүгээр баг, Засаг Даргын Тамгын Газар 1 дүгээр байр 106 тоот<br>Харилцах утас: 88101941 | “Экилешия” ХХК-ийн төлөөлж захирал ………………… Кан Мин Хо<br>Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг 14 хороо 3-р хороолол 11-34 тоот<br>Харилцах утас: 91997204, 94447204 |

## Хөрсний шинжилгээ

**ХӨРС СУДЛАЛЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**

**ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК**
Утас/Факс 77278899, 77288899
E-mail: soil_lab@geo-mongol.mn mn

MNAS

**Дугаар: 24/1900**

**Дээж авсан огноо:** 2024 он 10 сарын 25
**Шинжилгээ хийсэн огноо:** 2024 он 10 сарын 28-29
**Дээж авсан газрын нэр:** Дорноговь аймаг, Айраг сумын нутагт хэрэгжиж буй “Жоншт Толгойн хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах” төсөл
**Координат:** $45^{0}40^{I}3.55^{II}$ $109^{0}7^{I}14.94^{II}$
**Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: “**Экилешия” ХХК
**Харилцах утас:** 99275568

***Хөрсний химийн задлан шинжилгээний дүн***

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | pH | Давс, % | ЦДЧ, dsm | Ялзмаг,% | $NO_3$ мг/100г | $CaCO_3$,% | Шингээгдсэн суурьнуд мг-экв/100 гр | | Шим тэжээлийн элементүүд мг/ 100 гр | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | Ca | Mg | $P_2O_5$ | $K_2O$ |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| 1 | 24/5684 | Х-1 Ил уурхайн карьер-1 | - | 9.16 | 0.04 | 0.092 | 0.49 | 0.11 | 0.32 | 7.6 | 5.0 | 2.1 | 25 |

***Хөрсний механик бүрэлдэхүүн***

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 1-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 |
| 1 | 24/5684 | Х-1 Ил уурхайн карьер-1 | - | 35.4 | 50.1 | 1.3 | 5.9 | 4.8 | 2.5 | 13.2 |

*Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарах ба хуулбарлан хэрэглэхийг хориглоно.*

Шинжилгээ хийсэн арга стандарт:
(MNS 3310:1991, MNS ISO 10390:2001, MNS 6824:2020)

Лабораторийн эрхлэгч: Я.Болдбаатар /MS.c/

Задлан шинжээч: С.Ганцэцэг

**ХӨРС СУДЛАЛЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**

MNAS

**ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК**
Утас/Факс 77278899, 77288899
E-mail: soil_lab@geo-mongol.mn mn

**Дугаар: 24/1901**

**Дээж авсан огноо:** 2024 он 10 сарын 25
**Шинжилгээ хийсэн огноо:** 2024 он 10 сарын 28-29
**Дээж авсан газрын нэр:** Дорноговь аймаг, Айраг сумын нутагт хэрэгжиж буй “Жоншт Толгойн хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах” төсөл
**Координат:** 45⁰40ᴵ4.87ᴵᴵ 109⁰7ᴵ31.70ᴵᴵ
**Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн:** “Экилешия” ХХК
**Харилцах утас:** 99275568

***Хөрсний химийн задлан шинжилгээний дүн***

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | pH | Давс, % | ЦДЧ, dsm | Ялзмаг,% | $NO_3$ мг/ 100г | $CaCO_3$,% | Шингээгдсэн суурьнуд мг-экв/100 гр | | Шим тэжээлийн элементүүд мг/ 100 гр | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | Ca | Mg | $P_2O_5$ | $K_2O$ |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| 1 | 24/5685 | Х-2 Ил уурхайн карьер-2 | - | 8.74 | 0.10 | 0.205 | 0.38 | 0.09 | 0.32 | 7.8 | 5.9 | 1.7 | 19 |

***Хөрсний механик бүрэлдэхүүн***

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, мм | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 1-0.25 | 0.25-0.05 | 0.05-0.01 | 0.01-0.005 | 0.005-0.001 | <0.001 | <0.01 |
| 1 | 24/5685 | Х-2 Ил уурхайн карьер-2 | - | 29.5 | 34.3 | 4.6 | 21.3 | 9.8 | 0.5 | 31.6 |

*Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарах ба хуулбарлан хэрэглэхийг хориглоно.*
Шинжилгээ хийсэн арга стандарт:
(MNS 3310:1991, MNS ISO 10390:2001, MNS 6824:2020)

Лабораторийн эрхлэгч: Я.Болдбаатар /MS.c/
Задлан шинжээч: С.Ганцэцэг

**ХӨРС СУДЛАЛЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**

**ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК**
Утас/Факс 77278899, 77288899
E-mail: soil_lab@geo-mongol.mn mn

**Дугаар: 24/1902**

**Дээж авсан огноо:** 2024 он 10 сарын 25
**Шинжилгээ хийсэн огноо:** 2024 он 10 сарын 28-29
**Дээж авсан газрын нэр:** Дорноговь аймаг, Айраг сумын нутагт хэрэгжиж буй “Жоншт Толгойн хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах” төсөл
**Координат:** 45⁰40ᴵ2.75ᴵᴵ 109⁰7ᴵ51.53ᴵᴵ
**Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн:** “Экилешия” ХХК
**Харилцах утас:** 99275568

***Хөрсний хүнд метал***

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | *Хүнд металл мг/кг* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Ni /Никель/ | Cd /Кадми | Pb /Хар тугалга/ | Cu /Зэс/ | Zn /Цайр/ | Cr /Хром/ |
| 1 | 24/5686 | Х-3 Кемп орчим | - | 30.94 | ND | 44.27 | 14.10 | 41.59 | 26.44 |
| Хүлцэх агууламж /MNS 5850:2019/ | | | | 150,0 | 3,0 | 100,0 | 100,0 | 300,0 | 150,0 |
| Хортой агууламж /MNS 5850:2019/ | | | | 1000,0 | 10,0 | 500,0 | 500,0 | 600,0 | 400,0 |
| Аюултай агууламж /MNS 5850:2019/ | | | | 1800,0 | 20,0 | 1200,0 | 1000,0 | 1000,0 | 1500,0 |
| Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт | | | | /MNS 5850:2019/ | | | | | |

***ND-not detect**

***Жич:** Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарах ба хуулбарлан хэрэглэхийг хориглоно.*

Шинжилгээ хийсэн арга стандарт:
(MNS ISO 11466:2007)

Лабораторийн эрхлэгч: Я.Болдбаатар /MS.c/
Задлан шинжээч: С.Ганцэцэг

## ХӨРС СУДЛАЛЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ

**ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК**
Утас/Факс 77278899, 77288899
E-mail: soil_lab@geo-mongol.mn mn

**Дугаар: 24/1903**

**Дээж авсан огноо:** 2024 он 10 сарын 25
**Шинжилгээ хийсэн огноо:** 2024 он 10 сарын 28-29
**Дээж авсан газрын нэр:** Дорноговь аймаг, Айраг сумын нутагт хэрэгжиж буй “Жоншт Толгойн хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах” төсөл
**Координат**: 45⁰40ᴵ1.47ᴵᴵ 109⁰7ᴵ49.24ᴵᴵ
**Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: “**Экилешия” ХХК
**Харилцах утас:** 99275568

***Хөрсний хүнд металл***

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | Хүнд металл мг/кг | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Ni /Никель/ | Cd /Кадми | Pb /Хар тугалга/ | Cu /Зэс/ | Zn /Цайр/ | Cr /Хром/ |
| 1 | 24/5687 | X-4 ШТС | - | 27.82 | ND | 48.13 | 16.92 | 55.36 | 28.91 |
| Хүлцэх агууламж /MNS 5850:2019/ | | | | 150,0 | 3,0 | 100,0 | 100,0 | 300,0 | 150,0 |
| Хортой агууламж /MNS 5850:2019/ | | | | 1000,0 | 10,0 | 500,0 | 500,0 | 600,0 | 400,0 |
| Аюултай агууламж /MNS 5850:2019/ | | | | 1800,0 | 20,0 | 1200,0 | 1000,0 | 1000,0 | 1500,0 |
| Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт | | | | /MNS 5850:2019/ | | | | | |

***ND-not detect**

*Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарах ба хуулбарлан хэрэглэхийг хориглоно.*

Шинжилгээ хийсэн арга стандарт:
(MNS ISO 11466:2007)

Лабораторийн эрхлэгч: Я.Болдбаатар /MS.c/
Задлан шинжээч: С.Ганцэцэг

**ХӨРС СУДЛАЛЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**

**ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК**
Утас/Факс 77278899, 77288899
E-mail: soil_lab@geo-mongol.mn mn

**Дугаар: 24/1904**

**Дээж авсан огноо:** 2024 он 10 сарын 25
**Шинжилгээ хийсэн огноо:** 2024 он 10 сарын 28-29
**Дээж авсан газрын нэр:** Дорноговь аймаг, Айраг сумын нутагт хэрэгжиж буй "Жоншт Толгойн хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах" төсөл
**Координат:** 45⁰40ˈ2.05ˈˈ 109⁰7ˈ50.38ˈˈ
**Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн:** "Экилешия" ХХК
**Харилцах утас:** 99275568

***Хөрсний хүнд металл***

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | Хүнд металл мг/кг | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Ni /Никель/ | Cd /Кадми | Pb /Хар тугалга/ | Cu /Зэс/ | Zn /Цайр/ | Cr /Хром/ |
| 1 | 24/5688 | X-5 Авто зогсоол | - | 3.90 | ND | 13.51 | 3.17 | 28.66 | 2.39 |
| Хүлцэх агууламж /MNS 5850:2019/ | | | | 150,0 | 3,0 | 100,0 | 100,0 | 300,0 | 150,0 |
| Хортой агууламж /MNS 5850:2019/ | | | | 1000,0 | 10,0 | 500,0 | 500,0 | 600,0 | 400,0 |
| Аюултай агууламж /MNS 5850:2019/ | | | | 1800,0 | 20,0 | 1200,0 | 1000,0 | 1000,0 | 1500,0 |
| Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт | | | | /MNS 5850:2019/ | | | | | |

***ND-not detect**

*Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарах ба хуулбарлан хэрэглэхийг хориглоно.*

Шинжилгээ хийсэн арга стандарт:
(MNS ISO 11466:2007)

Лабораторийн эрхлэгч: Я.Болдбаатар /MS.c/
Задлан шинжээч: С.Ганцэцэг

**ХӨРС СУДЛАЛЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ**

MNAS

**ИНЖЕНЕР ГЕОДЕЗИ ХХК**
Утас/Факс 77278899, 77288899
E-mail: soil_lab@geo-mongol.mn mn

**Дугаар: 24/1905**

**Дээж авсан огноо:** 2024 он 10 сарын 25
**Шинжилгээ хийсэн огноо:** 2024 он 10 сарын 28-29
**Дээж авсан газрын нэр:** Дорноговь аймаг, Айраг сумын нутагт хэрэгжиж буй "Жоншт Толгойн хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах" төсөл
**Координат**: $45^{0}40^{I}2.42^{II}$ $109^{0}7^{I}49.87^{II}$
**Дээж шинжлүүлсэн байгууллага, хувь хүн:** "Экилешия" ХХК
**Харилцах утас:** 99275568

***Хорсний хүнд металл***

| № | Лаб № | Дээжний нэр | Гүн, см | Хүнд металл мг/кг | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Ni /Никель/ | Cd /Кадми | Pb /Хар тугалга/ | Cu /Зэс/ | Zn /Цайр/ | Cr /Хром/ |
| 1 | 24/5689 | Х-6 Засварын газар | - | 14.31 | ND | 6.23 | 3.81 | 17.15 | ND |
| Хүлцэх агууламж /MNS 5850:2019/ | | | | 150,0 | 3,0 | 100,0 | 100,0 | 300,0 | 150,0 |
| Хортой агууламж /MNS 5850:2019/ | | | | 1000,0 | 10,0 | 500,0 | 500,0 | 600,0 | 400,0 |
| Аюултай агууламж /MNS 5850:2019/ | | | | 1800,0 | 20,0 | 1200,0 | 1000,0 | 1000,0 | 1500,0 |
| Элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандарт | | | | /MNS 5850:2019/ | | | | | |

***ND-not detect**

*Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжинд хамаарах ба хуулбарлан хэрэглэхийг хориглоно.*

Шинжилгээ хийсэн арга стандарт:
(MNS ISO 11466:2007)

Лабораторийн эрхлэгч: Я.Болдбаатар /MS.c/

Задлан шинжээч: С.Ганцэцэг

## Усны шинжилгээ

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ГАЗАРЗҮЙ - ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН УСНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

### Усны химийн шинжилгээний тодорхойлолт

Сорьц авсан: 2024 оны 10 сарын 24 өдөр
Шинжилгээ хийсэн: 2024 оны 10 сарын 28 өдөр
Сорьц авсан газрын нэр: Дорноговь аймаг, Айраг сум шүүрлийн ус
Сорьц шинжлүүлсэн байгууллага, хувь хүн: "Экилешия" ХХК

Солбицол X= Y= Гүн: м Ундарга: л/с
Уст цэгийн төрөл ба дугаар: Шүүрлийн ус

Тодорхойлсон нь:

| Анион | 1 $дм^3$ -д байгаа | | | Катион | 1 $дм^3$ -д байгаа | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мг | мг-экв | мг-экв% | | мг | мг-экв | мг-экв% |
| $Cl^-$ | 102.2 | 2.88 | 10.2 | $Na^++K^+$ | 224.8 | 9.77 | 34.5 |
| $SO_4^{--}$ | 175.0 | 3.65 | 12.9 | $Ca^{++}$ | **253.3** | 12.64 | 44.6 |
| $NO_2^-$ | 0.20 | 0.00 | 0.0 | $Mg^{++}$ | **72.0** | 5.92 | 20.9 |
| $NO_3^-$ | 20.0 | 0.32 | 1.1 | $NH_4^+$ | 0.3 | 0.02 | 0.1 |
| $CO_3^{--}$ | 0.0 | 0.00 | 0.0 | $Fe^{++}$ | 0.0 | 0.00 | 0.0 |
| $HCO_3^-$ | 1,311.5 | 21.50 | 75.8 | $Fe^{+++}$ | 0.05 | 0.00 | 0.0 |
| Дүн | 1,608.9 | 28.35 | 100.0 | Дүн | 550.4 | 28.35 | 100.0 |

$HCO_3^-$ ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр: 1503.6 мг/ $дм^3$

Анион катионуудын нийлбэр: **2159.4** мг/ $дм^3$

Еренхий хатуулаг: **18.56** мг-экв/ $дм^3$
pH:**6.29**
EC:2400 µS/cm
Исэлдэх чанар: 1.44 мг/ $дм^3$
TDS:1440 ppm

**Физик шинж чанар**

Тунгалаг: 0 см
Өнгө: Цайвар бор
Үнэр: үгүй
Амт: ***
Тунадас: бор
Булингар: **59.8** NTU

Усны найрлагын томъёо: $M_{2.16} \frac{HCO_3^- 76\ SO_4^{2-} 13\ Cl^- 10}{Ca^{2+} 45\ Na^+ + K^+ 35\ Mg^{2+} 21}$

**Дүгнэлт**

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальци-натрийн бүлгийн, I-р төрлийн, чанарын хувьд давсархаг, маш хатуу, сул хүчиллэг орчинтой, эрдэсжилт, хатуулаг ихтэй, булингартай ус байна.

*Жич: Энэхүү уст цэгээс сорьц авах үйл явцыг шинжлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцан гүйцэтгэсэн болно.*

Шинжилгээ
Гүйцэтгэсэн: Химич, ЭШДэА ________ /...Энхжаргал/
Хянаж, баталгаажуулсан: Лабораторийн эрхлэгч: ________ /...Д.Гэрэлт-Од/

УСНЫ ЛАБОРАТОРИ